



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

┌ Албан журмын даатгагчдын холбооны ┐
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12¹.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Ш.Батчимэгийг чөлөөлж, “Файн эстимэйт” ХХК-ийн ерөнхий захирал Н.Цолмонгэрэл, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга М.Мөнхбаяр, Монголын даатгалын зуучлагчдын холбооны дэд ерөнхийлөгч, “Эрдэлийн шийдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Анхбаяр нарыг тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр баталсугай.

2. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Н.Цолмонгэрэл, М.Мөнхбаяр, Б.Анхбаяр нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000077